



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/407

Есөнбулаг

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 61 дүгээр тогтоолоор батлагдсан "Говь-Алтай 80+" эрүүл мэндийн хөтөлбөрийн 4 дүгээр зүйлийн зорилт 2, 7 дугаар зүйлийн 7.1.7, 7.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Говь-Алтай-80+" эрүүл мэндийн хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах, мөн явуулын үзлэг, оношлогоо, шинжилгээг зохион байгуулах ажлын хүрээнд 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрөөс 30-ны өдрүүдэд сумдад ажилласан багийн тайланг хэлэлцэж, тус арга хэмжээнд зарцуулагдсан зардлыг "Говь-Алтай-80+" эрүүл мэндийн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2.Нэгдсэн сургалт, ажлын төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулан батлуулж ажиллахыг ажлын хэсэг (Т.Мөнхбат)-т, урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулахад шаардагдах төсвийг боловсруулан, батлуулж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т, сургалт сурталчилгаа явуулах, урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулах баг бүрэлдэхүүн, эмч, мэргэжилтнийг томилж ажиллуулах, гүйцэтгүүлэх эрхийг Эрүүл мэндийн газар (Г.Лхагважаргал)-т олгосугай.

3.Шаардагдах 4,800,000 (дөрвөн сая найман зуу мянган) төгрөгийг "Говь-Алтай 80+" эрүүл мэндийн хөтөлбөрөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР

